

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

2018.10.15

Сонгон шалгаруулалтын нэр:

Засгийн газрын 2015 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 11 тоот тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм'-ийн 1.2, 3.1, 3.3 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн /дотор, мэдрэл, гэмтэл-мэс засал/ эмч нарын сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Сонгон шалгаруулалтын дугаар: ГСАНДХ-ЭХМК-01

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалийн хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмчээр ажиллах сонирхолтой мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулалтанд урьж байна.

Төрөлжсөн мэргэжлийн эмч нь тухайн мэргэжлийн дагуу иргэн (даатгуулагч)- ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах үйл ажиллагаанд оролцох үндсэн чиг үүрэгтэй ажиллана.

Төрөлжсөн мэргэжлийн эмчид тавигдах ерөнхий шаардлага:

- Эмчлэх эрхийн лицензтэй
- Эмчийн ахлах зэргээс дээш мэргэжлийн зэрэгтэй
- Анагаах ухааны магистраас дээш боловсролын зэрэгтэй
- Багаар ажиллах, үнэлгээ дүгнэлт өгөх чадвартай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах
- Ес зүйн зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ял шийтгэлгүй
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шаардлага хангасан

Бүрдүүлэх материал:

- Нэр дэвшүүлсэн байгууллагын санал, ажил байдлын тодорхойлолт /Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлын протоколын хамт/
- Нэр дэвшигчийн өөрийн хүсэлт
- Анкет /төрийн албан хаагчийн 1-р маягтаар/
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Боловсролын диплом, мэргэжлийн болон үйл ажиллагаатай холбоотой материалын хуулбар
- 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зураг
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын төрөлжсөн мэргэжлийн эмчид тавигдах шаардлагыг хангаагүй болон бүрдүүлэх материалыг дугуу ирүүлсэн мэргэжилтнийг сонгон шалгаруулалтанд бүртгэхгүй

Хугацаа:

Нэр дэвшигчийн материалыг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 09 цаг 00 минут хүртэлх хугацаанд хүлээн авна

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг
хөдөлмөрийн магадлах комисс

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 101, 201 тоот өрөө
Утас:91113920, 99955558

Сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дээрх хаяг, утсаар авч
болно.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДЭРГЭДЭХ ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ КОМИСС